

**АГУУЛГА**

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	1 – 7
ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	8 - 9
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ .....	9
СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	10 - 12
НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	13
ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	14
НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	14
ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	14
ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	15
ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	16
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	17 - 19
УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	20
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ.....	21 – 22
2021 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАНГИЙН ДҮГНЭХ ХУУДАС. ....	23 - 25

**ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

“Билэгт Баялаг” ХХК-ийн байгаль орчныг хамгаалах бодлогын гол зорилго нь Монгол улсын “Ашигт малтмалын тухай хууль”, “Байгаль орчныг хамгаалах тухай хууль” болон байгаль орчинтой холбогдох бусад хууль, дүрэм, журам, компанийн үндсэн бодлогын дагуу явуулахад оршино.

Манай компани нь MV-021008 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 178.98 га талбай эзэмшдэг бөгөөд 2017 онд хайгуул хийн нөөцөө баталгаажуулж Зүүндалан, Далангийн чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах ТЭЗҮ-ийг Кэйстоун ХХК боловсруулж 2018 онд батлуулсан.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын ажлыг “Саут Воли” ХХК 2018 онд боловсруулж БОАЖЯ-аар баталгаажуулсан байна. Байгаль орчны аудитын ажлыг эрх бүхий “Грийн сервис” ХХК 2021 онд хийж гүйцэтгэсэн.


*Төсөл хэрэгжиж буй газрын засаг захиргааны харьяалал*

Зүүндалан, Далангийн нүүрсний орд нь засаг захиргааны хуваарлалтаар Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Элдэв багийн нутагт Улаанбаатар хотоос зүүн урагш 270 км, Дорноговь аймгийн төв

Сайншанд хотоос баруун хойш 200 км, Даланжаргалан

сумын төвөөс баруун хойш 28 км, төмөр замын 25-р зөрлөг болон Улаанбаатар-Сайншандыг холбосон автозамаас 22 км зайд байрлах “Баруундалан”

хэмээх газрын зүүн хэсэгт орших ба физик газарзүйн мужлалаар тал хээр-говийн бүст хамаарна. Уг орд нь дэд бүтэц, зам харилцаа сайн хөгжсөн, цахилгаан эрчим хүчний төвийн шугам сүлжээнд холбогдсон бүс нутагт оршино.



*Зүүндалан, Далан тусгай зөвшөөрөлтэй талбайн солбилцол*

Цэгийн дугаар	Уртраг			Өргөрөг		
	Град	Мин	Сек	Град	Мин	Сек

## “БИЛЭГТ БАЯЛАГ” ХХК–ЗҮҮНДАЛАН, ДАЛАНГИЙН УУРХАЙ

1	108	58	1.63	46	8	11.66
2	108	58	1.63	46	7	51.66
3	108	58	21.62	46	7	51.66
4	108	58	21.62	46	7	31.65
5	108	56	41.63	46	7	31.65
6	108	56	41.63	46	7	51.66
7	108	57	26.62	46	7	51.66
8	108	57	26.62	46	8	11.66

### *Дэд бүтэц, зам харилцаа*

УБ хотоос төмөр замын 25-р зөрлөг хүртэл хатуу хучилттай замаар зорчино. Цааш уурхайн талбай хүртэл автомашинаар зорчихдоо бартаа саадгүй сайжруулсан шороон замын сүлжээтэй.

Уурхайн карьер, хөрсний овоолго, кемп, засварын газрууд нь хоорондоо шороон замаар холбогдсон. Уурхайгаас “МАК” ХХК-ийн сайжруулсан нүүрс тээврийн зам хүртэлх замын даланг уурхайн хөрс хуулалтаас гарсан хөрсөөр хийсэн ба технологийн тээврийн зам нь 20 м өргөнтэй нийт 1.4 км замын суурь нь 0.45 м зузаан, 0,25 метр хайрган хучилттай бөгөөд цаг агаарын байдалд тэсвэртэй, ус урсах боломжтой 100 хүртэл тонны даацтай тээврийн хэрэгслүүд явахад зориулагдсан. Харилцаа холбооны хувьд үүрэн телефоны оператор компаниудын сүлжээ нэвтэрсэн.

### *Геологийн тогтоц*

Алагтогоогийн чулуун нүүрсний ордыг агуулж буй грабен хэлбэрийн хотос структур нь хожуу мезозойн ревивацийн нөлөөллөөр үүссэн бөгөөд говийн атриат бүсэд хамаарагдана. Энд дээд юра-доод цэрдийн Цагаанцав формацийн бялхмал-тунамал хурдас, доод цэрдийн туфоген-тунамал хурдас, дөрөвдөгчийн эх газрын тунамал хурдас тархсан байдаг.

### *Физик газарзүй*

Уурхайн талбай нь намхан толгод зонхилсон тал хээрийн бүсэд багтах бөгөөд хамгийн өндөр цэг нь уурхайн талбайгаас зүүн хойш 3.7 км-т байрлах 1352.2 тоот өндөрлөг бол нам доор цэг нь уурхайн талбайгаас баруун тийш 7 км-т байрлах Бэхтийн-Улаан нуур /1179.6 м/ юм. Харьцангуй өндөржилт нь 50 м-с хэтрэхгүй.

### *Байгаль цаг уурын нөхцөл*

Ордын талбайн орчин тойрон нь эх газрын эрс тэс хуурай уур амьсгалтай. Даланжаргалан сум болон түүний орчин тойрны цаг уурын элементүүдийн сүүлийн 10 жилийн ажиглалтын дунджаар 16.5 мм хур тунадас унах бөгөөд үүний ихэнх нь 4-10-н сарын хооронд унана. 7-р сард дулааны дундаж хэм +25 градус, 01 сард -23 градус хүрч хүйтрэнэ. Дулааны улиралд +10 градусаас дээш хугацааны нийлбэр 2000-2800 градус,

ургамал ургалтын үе нь 120-130 хоног байдаг. Жилийн туршид гол төлөв баруун зүгийн салхи зонхилох ба 4, 5 саруудад салхины хүч эрчимждэг.

### *Хөрсөн бүрхэвч*

БОНБНҮ-ний хүрээнд хийгдсэн хээрийн судалгааны үр дүнд тус төслийн талбай орчим нь хөрс газарзүйн мужлалтын хувьд Хангайн их мужийн өргөрөгийн бүсшилттэй нутгийн Цайвархүрэн хөрсний дэд бүсийн хүрээнд Баяндэлгэрийн хөрсний тойрогт хамрагдаж байна. Төсөл хэрэгжиж буй бүс нутаг нь хуурай хээр, говийн бүсийн зааг толгодорхог ландшафт зонхилсон бөгөөд толгодын хэсгээр сайргархаг цайвархүрэн хөрс, харьцангуй тэгшивтэр гадаргаар карбонаттай цайвархүрэн хөрс, хөндий хотгорын хэсгээр хужирлаг бараан, зузаан элсэнцэр цайвархүрэн хөрс тус тус тархсан.

### *Ургамлын аймаг*

Төслийн талбай нь ургамлын мужлалаар Төв Азийн тал талархуу газрын ургамалжил бүхий Евразийн хээрийн их муж, хуурайдуу хэв шинжийн Алтанширээгийн тойрогт багтдаг ба газрын гадаргын хувьд цав толгод ухаа гүвээ, хотос хотгор, тойром бүхий гадарга зонхилох бөгөөд голлон тааралдах ургамлын хэв шинж нь бэсрэг уулсын налуу хажуу тал хөндийд крыловын хялгана-сөөгөнцөр, таана-сайрын хялгана, говийн хялгана-заримдаг сөөгөнцөр, дэрс бүхий таана-бударгана зэрэг цөлөрхөг хээрийн бүлгэмдэл зонхилсон байх бөгөөд элсэрхэг сайргархаг тэгш талархаг талаар Зүүнгарын улаанбударгана, сэдэргэнэ, таана зэрэг цөл хээрийн ургамалжилттай.

### *Гадаргын болон гүний ус*

Ус зүйн хувьд Төв Азийн гадагш урсгалгүй ай савын бүсэд хамаарах бөгөөд гидрогеологийн мужлалаар улирлын хомс тэжээлтэй мужид байрладаг. Энэхүү ай савд гол мөрний сүлжээ маш бага бөгөөд нэгж талбайд ноогдох голын нийлбэр урт нь 0.01 км/км. кв-аас доош байдаг. Даланжаргалан сумын нутаг нь “ Умард Говийн Гүвээт-Халхын Дундад Тал” усны сав газарт хамаарах бөгөөд гадаргын ус бараг байхгүй ба унд ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээнд газрын доорх усыг ашигладаг. Сансрын болон геологи-техтоникийн зураг, усны эрэл хайгуулын судалгааны дүнгээс харахад техтоникийн хагаралын бүсэд оршдог. Нүүрсний үе, давхраасууд нь синклиналь тогтоцтой, харьцангуй бага гүнд байрлах ба 5-10 градусын уналтай ба геологи, тектоникийн тогтоц нь энгийн бүтцийг үүсгэнэ. Усжилт бүхий тектоникийн хагарал, ан цав багатай, тохрол, өргөгдөл, суултанд олон удаа орсон блок байхгүй байна. Ул суурийн хурдас нь уст үе, давхарга багатай шаварлаг хурдас тухайлбал хар, хар саарал өнгийн аргиллит, алевролит, алевро-элсэнчулуу, шаварлаг чулуулгаас тогтох ба усжилт бага байдаг онцлогтой. Ордын гидрогеологийн нөхцлийн хувьд дээрх хүчин зүйлүүд **энгийн** нөхцөлтэй ангилалд оруулах боломжийг бүрдүүлж байна.

Ашиглаж байгаа худгийн мэдээлэл

Байршил	Худгийн нэр	Уурхайгаас байрлах зай	Худгийн гүн/ л.с	Зориулалт
Дорноговь, Даланжаргалан, Элдэв баг, Зүүндалан уурхай	Цооног 0603-18189	Уурхай н кемпийн хажууд	56 м/0.33	Унд, ахуй

*Амьтны аймаг*

“Билэгт Баялаг” ХХК-ийн Зүүндалан, Далангийн төслийн ойр орчим говь, цөлийн амьтад голчлон тархсан ба ихэнх нь “Монгол орны 2 нутагтан, мөлхөгчдийн улаан данс-2006 он”, “Монгол орны шувууны улаан данс-2011 он “Бүс нутгийн болон олон улсын үнэлгээний анхааралд өртхөөргүй /ЛС/ буюу өргөн тархац нутагтай элбэг гэсэн зүйл ангилалд орсон байна. Алагтолгой орчмын нүүрсний орд нь олон жилийн турш уул уурхайн хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөний улмаас амьтны аймгийн төрөл зүйлээр ядмаг юм.

*Түүх соёлын дурсгалт газрууд*

Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд 2018 онд ШУА-ийн Палеонтологийн төвийн доктор Н.Ичинноровоор ахлуулсан баг судалгааны ажлыг хийсэн ба талбайд археологийн болон соёлын үнэт зүйл бүхий зүйлс илрээгүй байна.

*Уурхайн үйл ажиллагааны талаарх мэдээлэл*

Зүүндалан, Далангийн чулуун нүүрсний ордыг агуулж байгаа грабен хэлбэрийн хотос структур нь хожуу мезозойн ревивацийн нөлөөллөөр үүссэн бөгөөд Говийн атриат бүсэд хамаарагдана. Алагтогоогийн нүүрсний ордын районд, дээд юрагийн тунамал хурдас, дээд юра доод цэрдийн Цагаанцав формацийн бялхмал тунамал хурдас, доод цэрдийн туфоген тунамал хурдас, дөрөвдөгчийн эх газрын тунамал хурдас тархсан байдаг. Нүүрс агуулсан хурдасны шинж чанарыг доор дурьдвал:

Аргиллит нь цайвар саарлаас хар саарал өнгөтэй, заримдаа шаравтар болон ногоовтор туяатай, ургамлын нүүрсжсэн үлдэгдэл, төмрийн усан ислийн хүрэн толбо (исэлдсэн хэсэгтээ), пирит (гүндээ) агуулсан, бүхэллэг (плотный) заримдаа конковатый хэлбэртэй байна.

Алевролит нь саарал өнгөтэй бүхэллэг, заримдаа конковатый хэлбэртэй мөн пирит болон төмрийн усан исэл агуулдаг болно. Нүүрсний давхраасны дээд талаар голчлон тааралддаг.

Элсэн чулуу нь шаравтар болон хүрэн туяатай, цагаан саарлаас саарал өнгөтэй, янз бүрийн ширхэгтэй, янз бүрийн мөлгөржилт бүхий янз бүрийн найрлагатай ширхэгүүдээс тогтоно.

Гравелит нь муухан мөлгөржсөн бялхмал болон цахиуржсан чулуулаг бүхий жижиг мөхлөгүүдээс тогтоно.

## “БИЛЭГТ БАЯЛАГ” ХХК–ЗҮҮНДАЛАН, ДАЛАНГИЙН УУРХАЙ

Конгломерат нь том хайргатай, хайрга нь дунд зэргийн мөлгөржсөн метаморф чулуулгаас тогтоно.

### Олборлолтын технологи

Ордын геологийн тогтоц, уул техникийн нөхцөлөөс хамааруулан хөрсөнд өрөмдлөг тэсэлгээтэй, экскаватор автосамсовалын хослолоор хөрсний гадаад болон дотоод овоолготой нүүрс олборлолтын ажил нь нүүрсийг уурхайгаас ухаж ачих, нүүрсийг төмөр замын Олон овоо өртөө хүртэл авто тээврээр тээвэрлэх гэсэн үндсэн процессуудаас бүрдэнэ. Ил уурхайн хэлбэр, хэмжээ, чулуулгийн технологийн шинж чанар зэрэг суурь нөхцөлүүдийг үндэслэн дараах механикжуулалтын бүтцийг хөрс хуулалт, олборлолтын ажилд тохиромжтой гэж үзэж байна.

### Уулын ажлын механикжуулалтын бүтэц

Хийгдэх ажил	Процесс	Тоног төхөөрөмж		
Шимт хөрс хуулалт	Ухаж түрэх	Экскаваци/тээвэр	Овоолох	
	Бульдозер	Экскаватор/автосамосвал	Бульдозер	
Хөрс хуулалт	Ухаж ачих	Тээвэрлэх	Овоолго	
	Экскаватор	Автосамосвал	Бульдозер	
Нүүрс олборлолт	Экскаваци	Тээвэр	Хадгалалт	Боловсруулалт
	Экскаватор	Автосамосвал	Агуулах	Угаан ангилах

### Уурхайн барилга байгууламж

Ажилчдын тосгон нь ил уурхайгаас 1.1 км зайд баруун зүгт 4 га талбайд байрладаг. Үүнд харуулын байр, уурын зуух, оффис, 90-100 хүний багтаамжтай сууц, нэг удаадаа 40 хүн хоолох хүчин чадалтай гал зуух, 5 хүн зэрэг ашиглах боломжтой нийтийн ариун цэврийн газар, өдөрт 8-10 хүний хувцас угаах хүчин чадалтай угаалгын өрөө, техник засварын газрууд тус тус байна.

Түлшний агуулах нь 10 тонны 1 ш, 25 тонны 1 ш дизельтүлш хадгалах ёмкостуудтай. Галын аюулаас сэргийлэх багаж техник, аянга зайлуулагч гэрэлтүүлэг зэргээр тоноглогдсон. 3000 литрийн багтаамжтай, тоолууртай, 100 л/мин шахах хүчин чадалтай явуулын түгээгүүрээр хүнд машин механизмуудад түлш тараадаг.



*Уурхайд ашиглаж буй техник, тоног төхөөрөмж*

Үзүүлэлт	<b>Doosan-DX700</b>
Утгуурын багтаамж, м <sup>3</sup>	4.5
Хөдөлгүүрийн чадал, кВт	345
Нийт жин, кг	70000
Гарны урт, м	8.4
Мах хурд км/цаг	5.2
Жилийн бүтээл, м <sup>3</sup>	1180000



Үзүүлэлт	<b>CAT-325DL</b>
Утгуурын багтаамж, м <sup>3</sup>	1.6
Хөдөлгүүрийн чадал, кВт	103
Нийт жин, кг	35100
Гарны урт, м	3.2
Мах хурд км/цаг	5.5
Жилийн бүтээл, м <sup>3</sup>	275000



Үзүүлэлт	<b>Shacman</b>
Даац, тн	70
Хөдөлгүүрийн чадал	426 м.х
Нийт жин, тн	25
Тэвшний багтаамж, м <sup>3</sup>	65
Хурд км/цаг	75
Жилийн бүтээл, м <sup>3</sup>	95660



Үзүүлэлт	<b>Nordbenz</b>
Даац, тн	25
Хөдөлгүүрийн чадал	371 м.х
Нийт жин, тн	13.7
Тэвшний багтаамж, м <sup>3</sup>	18.2
Хурд, км/цаг	70
Жилийн бүтээл, м <sup>3</sup>	160000



Үзүүлэлт	<b>Howo-371</b>
Даац, тн	70
Хөдөлгүүрийн чадал	371 hp
Мах хурд км/цаг	70
Жилийн бүтээл, м <sup>3</sup>	400000



Өрөмдлөгийн ажлыг 110мм-140мм диаметртэй эргэлтэт цохилтот өрмийн машинаар гүйцэтгэнэ.Нүүрсийг 3.2 м<sup>3</sup> утгуурын багтаамжтай SEM дугуйт ачигчаар 70 тонн даацтай шланз машинд ачина.

*2023 оны УАТөлөвлөгөө*

2023 онд нийт 549.120 мян.тн нүүрс олборлож, 1856.025 мян.м3 хөрс хуулалтын ажил хийж гүйцэтгэнэ. Нийт уулын цулын хэмжээ **2248.2 мян.м3** байхаар байна.

Уурхайн олборлосон нүүрсний 35% нь экспортын нүүрсний чанарын шаардлага хангана. Ихэнх нүүрс нь баяжуулалтанд орох шаардлагатай бохирдолтой нүүрс олборлогдоно. Баяжуулах үйлдвэр болон өндөр чанартай нүүрсний чанарыг бууруулах болон холилгоонд орох нүүрс нь нийт 356.928 мян.тн нүүрс, экспортын өндөр чанартай нүүрсний хэмжээ нь 192.19 мян.тн нүүрсийг тус тус борлуулна.

Уурхайн 2023 оны борлуулалтын орлого **25,753.728** сая төгрөг болно.



**ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ**

*Зуундалан, Далангийн чулуун нүүрсний ордын БОНБНУ-ний нэмэлт тодотгол-2018 он*

**Нөлөөллийн үнэлгээний нэгдсэн матриц**

№	Үзүүлэлтүүд	Агаарын чанар	Усны нөөц	Усны чанар	Ургамлын бүтэц	Амьтны аймаг	Геологийн тогтоц	Хөрсний хими, физик шинж чанар	Нийгэм эдийн засаг
1	Шимт хөрс хуулалт	2	0	0	9	2	0	6	1
2	Шимт хөрс хадгалалт	0	0	0	2	1	0	1	1
3	Суурь хөрс хуулалт	18	0	0	18	2	9	6	2
4	Суурь хөрс тээвэрлэлт	6	0	0	12	12	0	12	1
5	Хөрсний овоолго	12	0	0	8	2	0	8	1
6	Олборлолт	9	9	2	4	2	18	4	1
7	Хог хаягдал	2	0	1	4	0	0	4	1
8	Шатах тослох материалын агуулах	4	0	0	3	1	0	6	6
9	Засварын талбай	0	0	1	3	1	0	6	1
10	Нүүрс тээвэрлэх зам /1.1 км/	9	0	0	6	6	0	6	1

Өмнөх хүснэгтээс байгаль орчны хам бүрдэлд үзүүлэх сөрөг нөлөөлөл ба төслийн үйл ажиллагааны сөрөг нөлөөллийг эрэмблэн хүснэгтэнд оруулж ойлгомжтой байдлаар тайлбарлавал :

№	Байгаль орчны хам бүрдэл	Үзүүлэлт	Төслийн үйл ажиллагаа	Үзүүлэлт
1	Ургамлын бүтэц	69	Суурь хөрс хуулалт	55
2	Агаарын чанар	62	Олборлолт	49
3	Хөрсний физик, химийн шинж чанар	59	Суурь хөрс тээвэрлэлт	43

4	Амьтны аймаг	29	Хөрсний овоолго		31
5	Геологийн тогтоц	27	Нүүрс тээвэрлэх зам /1.4 км/		28
6	Нийгэм эдийн засаг	16	Шимт хөрс хуулалт		20
7	Усны нөөц	9	Шатах тослох материалын агуулах		20
8	Усны чанар	4	8	Хог хаягдал	12
			9	Засварын талбай	12
			10	Шимт хөрс хадгалалт	5

Дээрх хүснэгтээс харахад суурь хөрс хуулалт, олборлолт, суурь хөрс тээвэрлэлт, хөрсний овоолго үүсгэх, технологийн замаар нүүрс тээвэрлэх зэрэг үйл ажиллагааны улмаас ургамалан бүрхэвч, агаарын чанар, хөрсний физик химийн шинж чанар, амьтны аймаг зэрэг байгаль орчны хам бүрдэл бохирдох, багасах, хүний эрүүл мэндэд мэндэд муугаар нөлөөлөх, дайжих зэрэг гол сөрөг нөлөөлөл гарч болзошгүй гэж үзэж байна.

### ***БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ***

Энэхүү төлөвлөгөөний гол зорилт нь байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах.

БОНБУ-ний сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах талаарх заалтуудыг хэрэгжүүлэх, хэрэгжүүлэх боломжтой эсэхийг бодит байдал дээр турших.

Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгахыг зорих бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж ажиллаж байна.

<b>СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ</b>									
№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Агаарын чанар	Нүүрсний овоолгын уугилт, шаталтыг унтраах	Уурхайн талбай	удаа	50.000	Тухай бүр өөр гарна.	-	Тухай бүр	БО-ыг хамгаалах тухай хууль
		Уурхайн замуудад хуурайшилт ихтэй үед усалгаа хийх	Уурхайн талбай	удаа	50.000	Тухай бүр өөр гарна.	-	Тухай бүр	ХАБЭА-н тухай хууль, БО-ыг хамгаалах тухай хууль
		Уурхайн бүсийн замын суларсан шороог хусах	Уурхайн бүс	удаа	50.000	Тухай бүр өөр гарна.	-	Тухай бүр	ХАБЭА-н тухай хууль, БО-ыг хамгаалах тухай хууль

2.	Гадаргын ба газрын доорхи усны нөөц	Уурхайн унд болон ахуйн ус дамжуулах шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ашиглалтад байнга хяналт тавьж, гэмтсэн тохиолдолд засах арга хэмжээ авч ажиллана.	Уурхай нбүс	-	Тухай бүр өөр гарна.	-	-	Тухай бүр	MNS0900:2018. Хүрээлэн буй орчин, Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ
		Ус ашиглалтын мэдээг сар бүр төрөл тус бүрээр бүртгэнэ.	Уурхай нбүс	бүртгэл	-	-	-	Сар тутам	2023 оны ус ашиглуулах дүгнэлт
3.	Хөрсөн бүрхэвч	Тосоор бохирдсон хөрсийг цэвэрлэн саармагжуулах	Уурхай нбүс	1	5000	20	100.000	Тухай бүр	БО-ыг хамгаалах тухай хууль
		Мод тарих	Кемпийн урд	ш	10.000	50	500.000	5, 6-р саруудад	1 тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөн
		Засварын газар барих	Уурхайн бүс	ш	-	1	2023 оны үйл	5, 6-р саруудад	БО-ыг хамгаалах тухай хууль

							ажиллагаа ны орлогоос санхүүжүү лнэ		
		Кемпийн гаднах бие засах стандартын шаардлагад нийцүүлж шинээр хийх	Уурхайн бүс	1	2.000.000	1	2.000.000	2023 оны 6-р сард	Монгол улсын стандарт
4.	Газрын хэвлий	Шинээр газар шорооны ажил хийсэн үед шимт хөрсийг хуулж тусгай талбайд хадгална.	Уурхайн бүс	1	1.000.000	1	1.000.000	Тухай бүр	MNS 5916:2008 "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт
		Машин, механизм зогсдог талбайг цементлэх	Уурхайн бүс	1	2.000.000	1	2.000.000	5, 6-р саруудад	БО-ыг хамгаалах тухай хууль
5.	Ургамлан нөмрөг	Уурхай орчимд олон салаа зам гарахаас сэргийлж ажилчдад сургалт орох, анхааруулах тэмдэг байрлуулах	Уухайн бүс	1	50.000	2	100.000	Жилд 2 удаа	Стандартад нийцсэн тэмдэг байрлуулах
	<b>Нийт</b>						<b>5.700.000</b>		

**НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Техникийн нөхөн сэргээлт	Дотоод овоолго	га	2	-	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд хийх учраас зардал төлөвлөөгүй.	4-10-р сарын хооронд	Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS 5914 : 2008
2.	Биологийн нөхөн сэргээлт	Хөрсний овоолгын баруунталд хийхээр төлөвлөсөн.	га	1	6.000.000	6.000.000	4-6-р сарын хооронд	Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS 5914 : 2008
	<b>Нийт</b>					<b>6.000.000</b>		

**БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд болон Дорноговь аймгийн БОАЖГазраас өгсөн зөвлөмжийн дагуу	Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Бичигт нэртэй газарт 1 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийх	Техникийн нөхөн сэргээлт	1	1.000.000	1.000.000	2023 оны 8-р сард	Эвдэрсэн газрыг нөхөн сэргээж Даланжаргалан сумын ЗДТГ-т хүлээлгэж өгнө.
	<b>Нийт</b>			<b>1</b>		<b>1.000.000</b>		

**НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

“Билэгт Баялаг” ХХК нь 2023 онд нүүлгэн шилжүүлэх болон нөхөн олговор олгох арга хэмжээтөлөвлөхгүй.

**ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2018 онд “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн 6-р бүлгийн 17-р зүйлийн 10-т заасаны дагуу ШУА-ийн Археологи, Палентлогийн хүрээлэн төслийн талбайд хайгуулын ажлыг хийсэн. Судалгаа хайгуулын ажлын хүрээнд эртний ургамал амьтаны ул мөр, түүхийн үнэт олдвор илрээгүй. Иймээс 2023 онд төлөвлөхгүй.

**ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Ажлын байрны эрсдлийг бууруулах. Аюул, ослыг багасгах.	Аваар устгах төлөвлөгөө хийх	Зүүндалан, далангийн уурхай	1	500.000	500.000	Жилд 1 удаа	ХАБЭА-н тухай хууль
2.	Ажлын байрны эрсдлийг бууруулах, аюул, ослыг багасгах.	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө	Зүүндалан, далангийн уурхай	1	500.000	500.000	Жилд 1 удаа	ХАБЭА-н тухай хууль
3.	Ажлын байрны эрсдлийг бууруулах. Аюул, ослыг багасгах.	Гэнэтийн ослын даатгалд ажилчдыг хамруулах	Зүүндалан, далангийн уурхай	1	500.000	500.000	Жилд 1 удаа	ХАБЭА-н тухай хууль
4.	Ажлын байрны эрсдлийг бууруулах. Аюул, ослыг багасгах.	Ажлын байрны эрсдлийн үнэлгээ хийх	Зүүндалан, далангийн уурхай	1	500.000	500.000	Жилд 1 удаа	ХАБЭА-н тухай хууль
	<b>Нийт</b>					<b>2.000.000</b>		



<b>ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b>									
<b>№</b>	<b>Хог хаягдлын ангилал</b>	<b>Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ</b>	<b>Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ</b>	<b>Хэмжих нэгж</b>	<b>Нэгжийн зардал, төг</b>	<b>Тоо хэмжээ</b>	<b>Нийт зардал, төг</b>	<b>Хэрэгжүүлэх хугацаа</b>	<b>Баримтлах эрх зүйн баримт бичиг</b>
1.	<b>Ахуйн</b>	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан дахин ашиглах цэгт хүлээлгэн өгөх	Уурхайн бүс	кг	1000	200	200.000	2023 оны 4-р улиралд	Хог хаягдлын тухай хууль
2.	<b>Үйлдвэрийн</b>	-	-	-	-	-	-	-	-
3.	<b>Аюултай</b>	Аюултай хог хаягдлыг цуглуулан эрх бүхий байгууллагад хүргүүлэх	Уурхайн бүс	тн	200.000	3	600.000	Жилд 2 удаа	Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах журам
<b>Нийт</b>							<b>800.000</b>		

<b>ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР</b>								
<b>№</b>	<b>Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд</b>	<b>Хяналтын цэгийн байршил</b>	<b>Хугацаа ба давтамж</b>	<b>Давтамжийн тоо</b>	<b>Нэгжийн зардал, төг</b>	<b>Нийт зардал, төг</b>	<b>Тайлбар</b>	<b>Баримтлах стандарт, арга, аргачлал</b>
1	Хөрсний чанар- Хими физикийн ерөнхий үзүүлэлтүүд	ШТС, Засварын газар, кемпийн орчим.	Жилд 1 удаа	1	460.000	460.000	Мэргэжлийн лабораторид шинжлүүлнэ	MNS 3298:1990 Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд
2	Хөрсний чанар - Хүндметаллууд	ШТС, Засварын газар, кемпийн орчим	Жилд 1 удаа	1	460.000	460.000	Мэргэжлийн лабораторид шинжлүүлнэ.	MNS 3298:1990 Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд, MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ

3	Агаарын чанар – Тоос (PM2.5 ба PM10)	Карьерын гадна дотно орчин, кемпийн орчим, нөлөөлөлд өртөж болзошгүй үйлдвэрийн гаднах бүсэд	Жилд 1 удаа	1			Мэргэжлийн лабораторид шинжлүүлнэ.	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
4	Агаарын чанар - Орчны агаар дахь зарим хийнүүд SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , CO <sub>2</sub>	Карьерын гадна дотно орчин, нүүрсний талбай, кемпийн орчим, нөлөөлөлд өртөж болзошгүй уурхайн гаднах бүсэд	Жилд 1 удаа	1	600.000	600.000	Хэмжилтийн Dustрак багаж ашиглана.	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
5	Дуу шуугиан (гадаад орчны дуу шуугианы түвшин)	Карьерын гадаад дотоод орчин. кемп	Жилд 1 удаа	1	150.000	150.000	Дуу чимээ хэмжигч багаж ашиглана.	
6	Усны хими болон физикийн үзүүлэлт, рН, Эрдэсжилт, ЦДЧ, химийн үндсэн анион ба катион, умбуур бодис, хатуулаг, хүнд металлын агууламж	Унд ахуйн хэрэгцээнд ашигладаг худгаас	Жилд 2 удаа	1	180.000	180.000	Стандартын дагуу дээж авч лабораторид шинжлүүлнэ	MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ.

7	Эрүүл ахуй, бичил амьсудлалын үзүүлэлт, нийт бичил биетэн ба гэдэсний бүлгийн нийтнянгийн тоо (эмгэг төрүүлэгчийн тоо), өвчин үүсгэгч нян	Гал тогооны усан хангамжийн цоргоос	Жилд 2 удаа	1	220.000	220.000	Стандартын дагуу дээж авч лабораторид шинжлүүлнэ .	MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ, MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин, усны чанар, хаягдал ус ерөнхий шаардлага.
8	Эрүүл ахуй, бичил амьсудлалын үзүүлэлт, нийт бичил биетэн ба гэдэсний бүлгийн нийтнянгийн тоо (эмгэг төрүүлэгчийн тоо), өвчин үүсгэгч нян	Хаягдал ус хадгалах танкнаас	Жилд 2 удаа	1	220.000	220.000	Стандартын дагуу дээж авч лабораторид шинжлүүлнэ .	MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ, MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин, усны чанар, хаягдал ус ерөнхий шаардлага.
9	Амьтаны аймгийн төрөл зүйл, тоо хэмжээг бүртгэх	Үйлдвэрийн бүс болон нөлөөллийн бүсийн хэмжээнд	Жилд 1 удаа	1	100.000	100.000	Ажилчдаас аман байдлаар асууж бүртгэл хөтлөнө.	
<b>Нийт</b>						<b>2.390.000</b>		

**БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан
1	Ус ашиглах дүгнэлт, хаягдал усны дүгнэлт гаргуулж УГГХДТСГЗахиргаатай ус ашиглах гэрээ байгуулах	300.000	4-р сард	Захирал, БО-ны мэргэжилтэн
2	Хог хаягдлын гэрээг ЗДТГ-тайбайгуулж газрын төлбөр, хог хаягдлын төлбөр төлөх.	500.000	6, 11-р саруудад	Захирал, Санхүү
3	Ус ашигласаны төлбөрийг төлөх	Тодорхойлох боломжгүй, тоолуурын заалтаар төлнө.	11-р сард	Захирал, Санхүү
4	Аймаг, сумын зохион байгуулаххурал уулзалт, сургалтанд тогтмол хамрагдах.	1.000.000	Тухай бүр	Холбогдох албан тушаалтан, ИТАжилчид
5	Дотоод лабораторид ашиглах химийн бодисын зөвшөөрлийн БОАЖЯамнаас авах	200.000	2023 оны 1-р улиралд	Холбогдох албан тушаалтан
	<b>Нийт</b>	<b>2.000.000</b>		

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг газардэвр нь үзэж шалгах ажлын хэсгийн үзлэг шалгалт	Шалгалтын дүгнэлт	Байгаль орчны хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн үр дүн	2023 оны 11-р сард	300.000	Үйлдвэрийн дарга, БО-ны мэргэжилтэн	Зүүндалан, далангийн уурхай
2	2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг орон нутгийн захиргаанд хүргүүлэх, танилцуулах	Хэвлэсэн хэлбэрээр	2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, үр дүн	2023 оны 11-р сард	50.000	БО-ны мэргэжилтэн	Даланжаргалан сум

3	Даланжаргалансумын Элдэв багийн ард иргэд	Танилцуулга хэлбэрээр	Байгаль орчны чиглэлээр хийж хэрэгжүүлж байгаа ажлуудын талаарх мэдээлэл	2023 оны 3-р улиралд	100.000	Үйлдвэрийн дарга, БО-ны мэргэжилтэн	Даланжаргалан сум
4	Дорноговь аймгийн БОАЖГазар, УМГХДТСГЗахиргаа	Хэвлэсэн хэлбэрээр	Уурхайн 2023 оны ус ашиглалтын тайлан	2023 оны 3-р улиралд	50.000	БО-ны мэргэжилтэн	Сайншанд, Чойр
5	Дорноговь аймгийн БОАЖГазар	Хэвлэсэн хэлбэрээр	2022 онд хийгдсэн Зүүндалан, далангийн уурхайн БО- ныаудитын зөвлөмжийн дагуу хийсэн ажлын тайлан	2023 оны 3-р улиралд	200.000	БО-ны мэргэжилтэн	Сайншанд
<b>Нийт</b>					<b>700.000</b>		

**БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ЗАРЦУУЛАХ НИЙТ ЗАРДАЛ**

<b>№</b>	<b>БОМТ-ний бүрэлдэхүүн хэсэг</b>	<b>Зардал</b>
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	5.700.000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	6.000.000
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	1.000.000
4	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	2.000.000
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	800.000
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2.390.000
7	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	2.000.000
8	БОМТ-ний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	700.000
	<b>НИЙТ</b>	<b>20.590.000</b>